

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Чандмань-Илч” ХХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 223 дугаар тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Сайншанд сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Чандмань-Илч” ХХК (Д.Эрдэнэбаяр)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 460 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

П.ТОВУУДОРЖ

ЗОХИЦУУЛАГЧ

Л.ДАШМЯГМАРЖАВ

ЗОХИЦУУЛАГЧ

Ц.НОРОВЖАМЦ

ЗОХИЦУУЛАГЧ

Д.ЦОГОО

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

1. Дорноговь аймгийн Сайншанд сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно. Үүнд:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт		Төг/м ³	1,570.0
	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ	15,060.0
		тогтмол	Төг/м ³	970.0
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт		Төг/м ³	1,200.0
	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ	12,290.0
		тогтмол	Төг/м ³	780.0
3	Төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан		Төг/м ³	2,560.0
			Төг/хүн	3,840.0
4	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “0”-ын өрөөний халаалт хамаарна)		Төг/м ²	800.0
5	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан		Төг/м ³	2,500.0
			Төг/хүн	3,500.0
6	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	41 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	3,000.0
		41-81м ² талбайтай айл өрх	Төг/сар	5,000.0
		81 м ² -с дээш талбайтай айл өрх	Төг/сар	10,000.0